

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний аудитын газар
2022 оны 3 дугаар сар

АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт	3
Аудитын нэр.....	4
Аудитын код.....	4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилт	4
Аудитын хамрах хүрээ	4
Үндсэн мэдээлэл	5
Эрсдэлийн үнэлгээ	6
Аудитын арга зүй.....	7
Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд	7
Аудит хийх хугацаа	9
Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	9
Аудитын хөтөлбөр.....	9
Аудитад шаардагдах нөөц	10

Хавсралт №1 Аудитын сэдвийн эрсдэлийн үнэлгээ

Хавсралт №2 Асуудлын шинжилгээ

Хавсралт №3 Аудитын загварын матриц

Хавсралт №4 Аудитын хөтөлбөр

Хавсралт №5 Материаллаг байдлын тооцоолол

Хавсралт №6 Аудитын үр өгөөжийн төлөвлөлт

Хавсралт №7 Шинжээчийн ажлын даалгавар

Товчилсон үгсийн жагсаалт

Товчлол	Тайлал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
ГХОХХК	Гадаадын хөрөнгө оруулалттай Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ОНӨОХХК	Орон нутгийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ТАГ	Төрийн аудитын газар
ТӨ	Төрийн өмч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨО	Төрийн өмчийн оролцоотой
ТӨОХХК	Төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨОХК	Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХЯ	Эрчим хүчний яам

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

БАТЛАВ

Д.ЗАНДАНБАТ

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аудитын нэр

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

Аудитын код

АГГ-2022/22-ШТА-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.

Аудитын зорилго

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэнэ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ.Үүнд:

1. Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх;
2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх;
3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, холбогдох салбарын яам, төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллага, агентлаг, тэдгээрийн ажлын албадын 2019-2021 оны үйл ажиллагааг хамруулна.

Аудитын урьдчилсан судалгааны явцад Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой Монгол Улсад бүртгэлтэй 300 гаруй хуулийн этгээдийн салбарын онцлог, хувьцаа эзэмшлийн хувь, үйл ажиллагааны чиглэл, ашиг

алдагдлын хэмжээ, төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй хэлбэрээс хамаарч, нийт олонлогийг төлөөлөхүйц 80 гаруй хуулийн этгээдийг түүврээр сонгон, компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэхээр аймаг, нийслэл дэх ТАГ-тай хамтран аудитыг нэгдсэн удирдамжаар гүйцэтгэнэ.

Аудитад СЗХ, Монгол банк, ЗГХЭГ, Сангийн яам, салбарын яамд, ТӨБЗГ, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Компанийн засаглалын үндэсний зөвлөл ТББ, Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдүүд, мэргэжлийн байгууллага, бусад холбогдох байгууллагыг хамруулна.

Үндсэн мэдээлэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг 1996 онд баталсан бөгөөд тус хуульд 29 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8, 9, 11, 12 дугаар зүйлд төрийн өмчийн талаар дараах байгууллагын эрхийг хуульчилсан байна. Тухайлбал:

- **УИХ:** Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хэмжээг тогтоох, төрийн өмчийг барьцаалах, шилжүүлэх, хувьчлах зэрэг асуудлаар шийдвэр гаргах;
- **Засгийн газар:** Төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, дүрмийг батлах, бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах зэрэг төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг хариуцах;
- **ТӨБЗГ:** Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх, эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах. Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагаатай тохиролцон тогтоох. Засгийн газраас баталсан жагсаалтын дагуу эд хөрөнгийг хувьчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах, Орон нутгийн өмчийг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих;
- **Яам, тусгай газар:** Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагаатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулах.

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар, нийтийн болоод хувийн холимог өмчөөр хуулийн этгээд байгуулж болох хуулийн зохицуулалттай бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад бүртгэлтэй ТӨҮГ, ТӨХК, ТӨОХХК, ОНӨҮГ, ОНӨХК, ОНӨОХХК зэрэг нийт 324 хуулийн этгээд үйл ажиллагаагаа явуулж байна. Тухайлбал:

№	Хуулийн этгээдийн ангилал	Төрийн болон орон нутгийн өмчит				
		Үйлдвэрийн газар	ХК	ХХК	ГХОХХК	Хуулийн этгээдийн тоо
1	Төрийн өмчит хуулийн этгээд	61	63	54	5	183
2	Орон нутгийн өмчит хуулийн этгээд	96	9	36	0	141
Хуулийн этгээдийн нийт тоо		157	72	90	5	324

Эх сурвалж: Улсын бүртгэлийн Ерөнхий газар, УАГ

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг үйл ажиллагааны чиглэлээр эрчим хүч, зам тээвэр, уул уурхай, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, аялал жуулчлал, барилга, хөдөө аж ахуй, газар тариалан, банк, санхүү, даатгал, харилцаа холбоо, бусад гэж ангилж байна.

Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой 106 хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг ТӨБЗГ 49, ЗГХЭГ 1, Сангийн яам 6, ЭХЯ 26, ХХААХҮЯ 1, ЗТХЯ 2, УУХҮЯ 3, “Эрдэнэс Монгол” ХХК 17, “Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК 1-ийг нь тус тус хэрэгжүүлж, ТУЗ-ийн 635 гишүүнээс ТӨХК 423, ТӨХХК 130, ТӨОК 76, ХНН 6 гишүүн ажиллаж байна. Тухайлбал:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцаа эзэмшигчийн хувь, хуулийн этгээдийн тоо										ТӨ,ТӨО-той хуулийн этгээдийн тоо	
		100	70	66	50	49	34	30	30	30	26 ²		
1	ТӨБЗГ	49					1 ¹					49	
2	ЗГХЭГ	1										1	
3	Сангийн яам	6											6
4	Эрчим хүчний яам		26									26	
5	ХХААХҮЯ	1										1	
6	ЗТХЯ			1	1							2	
7	УУХҮЯ	3										3	
8	“Эрдэнэс Монгол” ХХК	7					10					17	
9	“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК					1						1	
Хуулийн этгээдийн дүн		67	26	1	1	1	11	26				106	
Эх сурвалж: ТӨБЗГ													

Аудитын урьдчилсан судалгаагаар Төрийн өмчит 182 хуулийн этгээдийн 51,698.1 тэрбум, орон нутгийн өмчит 141 хуулийн этгээдийн 6,087.9 тэрбум, нийт 57,786.0 тэрбум төгрөгийн хөрөнгө байна.

ТӨБЗГ-ын судалгаагаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээдийн санхүүгийн үзүүлэлтээр 2016 онд 41 хувь нь ашигтай, 59 хувь нь ашиггүй ажиллаж байсан бол 2019 онд 71 хувь нь ашигтай 29 хувь нь ашиггүй ажиллаж, Төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн орлогоор 2019 онд 155,2 тэрбум, 2020 онд 172,4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компанид 2020 оны байдлаар нийтдээ 51210 хүн ажиллаж, үйл ажиллагаа явуулснаас улс, орон нутгийн төсөвт татвар, хураамж, төрөл бүрийн төлбөр хэлбэрээр 2019 онд 2.0 их наяд төгрөг төвлөрүүлж, улсын төсвийн 20 орчим хувийг бүрдүүлсэн байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5.2.19-т “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж тус тус заасан байна.

Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн. (Хавсралт 1)

¹ ТӨБЗГ нь 34 хувь эзэмшигч 1 хуулийн этгээдийн 66 хувь эзэмшигч нь ЗТХЯ тул тус яамны дүнд оруулсан
² ТӨБЗГ нь 30 хувь эзэмшигч 26 хуулийн этгээдийн 70 хувь эзэмшигч нь Эрчим хүчний яам тул тус яамны дүнд оруулсан болно.

Б.Н

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МУЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглаж гүйцэтгэнэ.

Аудитаар “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т оролцогч хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин, Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан холбогдох бодлогын зорилтын хэрэгжилт, хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт судалгаа хийх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хяналтын тогтолцооны үр нөлөө зэрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулах, үнэлгээ хийх, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж ажиллана.

Аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулна. (Хавсралт 2, Хавсралт 3)

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

Хууль

- Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2³, 6 дугаар зүйлийн 6.2⁴ дахь хэсэг; /1992 он/
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2016, 2020/
- Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль /1993/
- Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль /2004/
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /1996/
- Компанийн тухай хууль /2011/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /2005/
- Авлигын эсрэг хууль /2006/
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль; /2015 он/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; /2020 он/
- Төсвийн тухай хууль; /2011 он/
- Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай 2017 он, 2018 он, 2019 он, 2020 оны хууль
- Монгол Улсын Төсвийн тухай 2017 он, 2018 он, 2019 он, 2020, 2021 оны хууль,
- Төрийн албаны тухай хууль /2017/
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль /2003/
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2006, 2021/

³ Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална

⁴ Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль /2010/
- Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2012/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015/
- Татварын ерөнхий хууль /2019/

Улсын Их Хурлын тогтоол

- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”;
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- УИХ-ын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”
- УИХ-аас гаргасан холбогдох бусад тогтоол,

Засгийн газрын тогтоол

- Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоол “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг тодотгон батлах тухай;
- Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоол “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”;
- Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоол “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”;
- Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоол “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”
- Засгийн газрын 2016 оны 91 дүгээр тогтоол “Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
- Засгийн газраас гаргасан холбогдох бусад тогтоол, шийдвэрүүд

Бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд

- Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”;
- Байгууллагын засаглалын олон улсын удирдамж ISO 37000 стандарт;
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан Компанийн засаглалын зарчмууд;
- УСНББОУС, НББОУС болон бусад стандартууд;
- Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/06 тушаалаар баталсан “Татвар төлөгчийг бүртгэх журам”

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”
- Эрчим хүчний төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам”

Аудит хийх хугацаа

Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн дотор Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулна.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 7 дугаар сарын 08-ны өдрийн дотор гүйцэтгэх бөгөөд аудиторууд талбарын ажлын явцад аудитын дэд тайланг зэрэгцүүлэн бичиж, үе шатны чанарын хяналтыг хийлгэн, нэгдсэн тайланг 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэн, Аудитын зөвлөлийн хурлаар 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хэлэлцүүлж, Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулж, батлуулна.

Аудитын тайланг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Улсын Их хурлын Эдийн засгийн Байнгын хороо, Засгийн газар, холбогдох Төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлнэ.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын Гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгосүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор М.Наранжаргал, аудитор Б.Булган, Ж.Мөнхбилгүүн, Э.Уужимсан нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аймаг, орон нутгийн Төрийн аудитын газруудын аудитын багийг аудитын нэгдсэн арга зүйгээр хангаж гүйцэтгэнэ.

Аудитын хөтөлбөр

Асуудлын шинжилгээнд тусгасан асуудлаар багийн гишүүдийн гүйцэтгэх ажлыг хуваарилж, аудитын хөтөлбөрт тусгав. (Хавсралт 4)

Аудитад шаардагдах нөөц

Аудитад шаардагдах зардлын төсөв, түүний тооцоолол. Үүнд:

А. Боловсон хүчин: УАГ-аас 4 хүн х 174 өдөр = 696 хүн/өдөр
Аудитын гуравдугаар газрын захирал болон
аудитын менежерийн хяналт 15 хүн/өдөр

⁵ Аудиторуудын цалинг үндсэн цалингаар тооцоолон 1 өдрийн цалинг дунджаар тооцоолов

⁶ Газрын захирал, аудитын менежерийн цалинг үндсэн цалингаар тооцоолон 1 өдрийн цалинг дунджаар тооцоолов

В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, диктафон, зургийн аппарат, бусад техник хэрэгсэл.

Аудитын төлөвлөгөөг хянаж, зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ Я.САРАНСҮХ

Хянасан:

АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.ЭНХБОЛД

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДОЛГОРСҮРЭН

Боловсруулсан:
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

М.НАРАНЖАРГАЛ
Б.БУЛГАН
Ж.МӨНХБИЛГҮҮН
Э.УУЖИМСАН

2022 оны 03 дугаар сарын 31-ны өдөр